



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 07 сарын 13 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 295 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цэвэграш овогтой Эрдэнэчулууныг АНУ-ын Пенсильванийн Их сургуулиас АНУ-ын Колумбын Их сургуулийн төрийн захиргааны удирдлагын магистрантурт шилжүүлэн суралцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчийн гэрээг сунгаж, сүүлийн нэг жилийн сургалтын зардлыг АНУ-ын Колумбын Их сургууль руу шилжүүлэхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД - г

А.ЦАНЖИД